



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

□ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай □

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан “Монгол даатгал” ХК-ийн нэр бүхий 5 иргэн, “Тэнгэр даатгал” ХХК-ийн нэр бүхий 1 иргэний даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.


2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан даатгалын гэрээ, баталгааны үлдэгдлийн тооцоог хийж, ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг “Монгол даатгал” ХК /Ч.Энх-Амгалан/, “Тэнгэр даатгал” ХХК /Ж.Мөнхсайхан/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох иргэдийн мэдээлэл

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар	Даатгалын компанийн нэр
1	Ганбаатар	Уранбаяр	Ч387060162	2016.11.09	264 дүгээр тушаал	2/04/231/1477	
2	Болд	Ууганбаяр	ФБ82071134	2016.11.09	264 дүгээр тушаал	2/04/231/1476	
3	Даваажав	Нямсүрэн	УХ88060540	2014.07.04	199 дүгээр тушаал	2/04/231/1332	“Монгол даатгал” ХК
4	Даваажав	Нямдаваа	УШ89100949	2014.07.04	199 дүгээр тушаал	2/04/231/1334	
5	Оюун-Эрдэнэ	Бархасцэнд	ШУ91082926	2013.05.24	137 дугаар тушаал	2/04/231/1127	
6	Мягмарсүрэн	Ганболд	ЧК79060377	2018.10.29	578 дугаар тушаал	2/12/231/616	“Тэнгэр даатгал” ХХК